



МУХАҮТ-ЫН 2016 ОНЫ I ХАГАС ЖИЛИЙН ТОВЧТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2016

ГИШҮҮНЧЛЭЛ

2016 оны эхний хагас жилийн байдлаар үндэсний танхимд шинээр 86 гишүүн байгууллага элссэн бөгөөд нийт гишүүдийн тоо **3161** болсон. Үүнээс орон нутгийн салбар танхимын гишүүн байгууллагууд – 2097 үндэсний танхимын гишүүн байгууллага – 1064 байна.

- Үндэсний танхимын гишүүдийн ангилал
 - Diamond - 154
 - Platinum - 53
 - Gold - 124
 - Classic - 714
 - Сурвалжлагч – 19

Элсээд нэг жил болсон 10 гаруй гишүүн компаний үйл ажиллагаатай танилцах аян, шинэ гишүүний гэрчилгээ гардуулах үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулсан.

№	Оны онцлох аж ахуй нэгжтэй танилцах аялал	Хамрагдсан хүний тоо
1.	Байгальд ээлтэй ногоон технологи нэвтрүүлэгч Ультрасоник ХХК-тай танилцах аялал	60
2.	ООААН-ийн аян - Тээвэр логиستيкийн салбарын 2015 оны онцлох ААН, Entrepreneur УБТЗ-ын ОУТЗТөв	30
3.	Хөдөө орон нутаг руу чиглэсэн аянг 2 дахь удаагаа зохион байгуулж буй "2015 оны онцлох Аж ахуй нэгжийн нэг"-ээр шалгарсан Эрдэнэт Үйлдвэр ХХК, Шарын гол ХХК, Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр, Дарханы Дулааны Цахилгаан Станц, Дархан Минж ХХК -ниудын үйл ажиллагаа, ажлын туршлагатай танилцах аялал	25
4.	Ай Ти Зон ХХК-тай танилцах аялал	30
5.	Шунхлай ХХК-тай танилцах аялал	45
	Нийт дүн	190

БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

№	Хууль, журам, хуулийн төсөл, бодлогын бичиг баримт	Төлөв
1.	Органик хүнсний тухай	Батлагдсан /2016.04.07/
2.	Барилгын тухай /Шинэчилсэн найруулга/	Батлагдсан /2016-02-05/
3.	Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх жрумын тухай	Батлагдсан /2016-02-05/
4.	Демпингийн тухай	Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдсэн
5.	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	УИХ-д өргөн баригдсан
6.	Татварын ерөнхий хууль	Төсвийн байнгын хороогоор дэмжигдсэн
7.	Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль	УИХ-д өргөн баригдсан
8.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах тухай хууль	УИХ-д өргөн баригдсан
9.	Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тухай	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдсэн
10.	Хэмжилзүйн тухай хууль	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдсэн
11.	Худалдааны тухай хууль	УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор дэмжигдсэн
12.	Хөдөлмөрийн тухай хууль	УИХ-аас дэмжлэг авахгүй буцаагдсан.
13.	Монгол улсын үндэсний чанарын бодлого, чанарын хөтөлбөр	Засгийн газрын хуралдаанаар батлагдсан.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хэлэлцэгдэх гэж байгаатай холбогдуулан МҮХАҮТ-аас «Хөдөлмөрийн харилцаан дах эрх зүйн орчин» сэдэвт В2В уулзалт, Хөдөлмөрийн хуулийн хэлэлцүүлгийн тус тус бизнес эрхлэгчдийн дунд зохион байгуулсан бөгөөд шинэ хуулийн төсөлд 30-аад байгууллага саналыг тусган боловсруулж Хөдөлмөрийн яаманд хүргүүлсэн. Энэ саналд Хамтын хэлэлцээ, Хамтын гэрээ, хэлэлцээр, Жасаагаар ажиллуулах, Хөдөлмөрийн сонирхлын маргааны зохицуулалт, Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулалт, Хөдөлмөрийн удирдлага, хяналт гэсэн 6 бүлгийг бүхэлд нь өөрчлөн найруулах, 3 зүйлийг хасах, 7 зүйлийг эргэж харах, тодорхой болгох, 37 зүйлийг өөрчлөн найруулахаар тусган саналаа Хөдөлмөрийн яамд хүргүүлсэн. 12 саналыг хуулийн төсөлд тусгасан.

ХУДАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Худалдааны тухай хуулийн төслийг Аж үйлдвэрийн яамны болон ЗГ-ын хуулийн дэд ажлын хэсэгт орж ажилласан. Хуулийн төслийг боловсруулахад “гадаад худалдааны цахим нэг цонх”-ны тухай заалтуудыг нэмж оруулахаар саналаа өгсөн.

Хуулийн төслийг боловсруулах олон удаагийн ажлын хэсэгт ажиллаж, 5-р сарын 18-ны өдрийн УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хурлаар Гадаад худалдааны тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт орж 100% дэмжигдсэн. Уг хурлаар 54 хэлэлцүүлэх саналыг нэг бүрчлэн танилцуулсан болно. УИХ-ын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орсоноор 9 сард уг хуулийн төслийг хэлэлцэхээр болсон.

Доорхи бодлогын бичиг баримт, хуулийн төслүүдийг боловсруулахад ажлын хэсэгт орж ажилласан

№	Ажлын хэсгийн нэр	Хийгдсэн ажил
1.	УИХ дахь Арбитрын хуулийн ажлын хэсэг	Арбитрын хуулийн шинэчилсэн найруулгад Танхимаас дэвшүүлсэн 11 салын 9 саналыг тусгуулсан.
2.	Монгол улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө батлах ажлын хэсэг	Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөг 2 удаагийн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зарлан зохион байгуулж төлөвлөгөөний төслийг гарган Үндэсний зөвлөлөөр батлуулсан.
3.	Органик хүнсний тухай хуулийг дагаж гарах журмуудын ажлын хэсэг	Одоо журам боловсруулах ажлын хэсэгт орж ажиллаж байна.
4.	ХХААЯ-ны Сав баглаа боодлын үндэсний хөтөлбөр	Санал өгсөн.
5.	Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх, холбогдох талуудын хамтран ажиллах	Гарал үүслийн гэрчилгээ олгох тухай санал
6.	Чөлөөт худалдааны хэлэлцээрийн судалгааны ажлын хэсэг	Санал өгсөн.
7.	Монгол улсыг гадаадад сурталчилах хөтөлбөр	Хөтөлбөр боловсруулсан.
8.	Гадаад худалдааны цахим нэг цонхны үндэсний хөтөлбөр	Төлөвлөгөөний төсөл боловсруулан гаргасан
9.	Экспортын үйлдвэрлэлийг дэмжих стратеги хөтөлбөр	Санал өгсөн.
10.	АҮЯ-ны “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр 2016-2020 он	Ажлын хэсэгт орж саналаа өгсөн.
11.	“Согтууруулах ундааны техникийн зохицуулалт”	Санал өгсөн.
12.	Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	Санал өгсөн.

МҮХАҮТ-аас 2016 онд нийт 59 хороо, зөвлөл, комисст гишүүнээр төлөөлөн орж ажлын хэсэгт оролцон ажиллаж, саналаа илэрхийлэн дуу хоолойгоо хүргэж байна.

Зохион байгуулсан хэлэлцүүлэг

1. Дэмпингийн тухай хуулийн хэлэлцүүлэг
2. Хөдөлмөрийн тухай хуулийн хэлэлцүүлэг
3. Импортын зарим барааны гаалийн татварыг нэмэгдүүлсэнтэй холбоотой компани аж ахуйн нэгжүүдтэй хийсэн хэлэлцүүлэг
4. Цементийн импортын бизнес эрхлэгчдийн уулзалт хэлэлцүүлэг
5. Худалдаа, тээврийг хөнгөвчлөхөд логистикийн гүйцэтгэх үүрэг сэдэвт өдөрлөг, хэлэлцүүлэг
6. Барилгын салбарын хууль эрх зүйн орчины хэлэлцүүлэг
7. “Төрөөс экспорт, импортын хүнсний бүтээгдэхүүний талаар баримталж буй бодлого” түүний хэрэгжилтийн тухай хэлэлцүүлэг
8. Монголын банкуудын холбоо, барилгын салбарын гарц, боломж хайсан хэлэлцүүлэг уулзалт

Гаргасан мэдэгдэл, тунхаг, уриалга:

1. Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, МҮХАҮТ-ын Бичил санхүүгийн байгууллагуудын хөгжлийн зөвлөл хамтран “Хүртээмжтэй санхүүжилтын санаачилгыг хэрэгжүүлцгээе” тунхаг бичиг
2. “Улс орны эдийн засаг тогтвортой байдлыг нэхэж байна” мэдэгдэл
3. “Бизнес эрхлэгчдэд чиглэсэн оновчтой бодлогыг дэмжинэ” уриалга

ЗОХИОН БАЙГУУЛСАН ТОМООХОН АРГА ХЭМЖЭЭ

ТОП-100 аж ахуй нэгж шалгаруулалт

“ТОП-100” аж ахуйн нэгжийг шалгаруулах ажлыг 15 дах жилдээ Сангийн яам, Гааль, татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газартай хамтран амжилттай эрэмбэлж 4-р сарын 27-ны өдөр Төрийн ордонд шагнал гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулсан.



“Алтанбулаг экспо-2016” арга хэмжээ

2016 оны 5 дугаар сарын 18-23-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг чөлөөт бүсэд “Алтанбулаг экспо 2016” арга хэмжээг Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам, МҮХАҮТ-ын Сэлэнгэ аймаг дахь салбар танхимтай хамтран амжилттай зохион байгуулсан.

“Алтанбулаг экспо 2016” олон улсын форум, үзэсгэлэнг зохион байгууласнаар 2016.05.21-22-ы өдрүүдэд Алтанбулагийн чөлөөт бүс рүү 2850 тээврийн хэрэгсэл, 9229 зорчигч нэвтэрч, БНХАУ-ын талаас 30 гаруй, ОХУ-ын талаас 20 гаруй, манай талаас 50 орчим бизнес эрхлэгч, мөн тооны хөрөнгө оруулагчид, эрдэмтэн судлаачид оролцсон.

Аж үйлдвэрийн сайдтай хамтран МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч энэ үеэр Алтанбулаг чөлөөт бүсийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах асуудлын хүрээнд Буриад улсын Ардын их хурлын дарга дарга Ц.Э. Доржиев. болон БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Шин Хаймин нартай уулзалт хийсэн.

“Алтанбулаг экспо 2016” олон улсын форум, үзэсгэлэнд дотоодын 120 гаруй аж ахуй нэгж оролцож, бараа, бүтээгдэхүүнээ танилцуулсан бөгөөд үзэсгэлэнгийн үеэр 112.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн болно.



“B2B meeting”

Бизнес эрхлэгчдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, тодорхой асуудлын талаарх мэдээллийг хуваалцах, санал солилцох чөлөөт индэрийг бий болгох зорилгоор B2B уулзалтуудыг тодорхой сэдвийн хүрээнд 4 удаа зохион байгуулж тухайн асуудал хариуцсан төрийн байгууллагын төлөөлөл, салбарын туршлагатай эрдэмтэн судлаач, мэргэжлийн экспертүүд болон бизнес эрхлэгчид гээд нийт давхардсан тоогоор **434** хүмүүсийг хамруулан зохион байгуулсан.

№	Арга хэмжээний нэр	Хэзээ	Оролцогсдын тоо
1.	Corporate & start-up	4-р сарын 29	100 орчим старт ап 20 томоохон аж ахуй нэгж
2.	“Хөдөлмөрийн харилцаан дахь эрх зүйн орчин”	2-р сарын 26	73 бизнес эрхлэгч, албаны төлөөлөл оролцсон.
3.	Тогтвортой хөгжил ба тогтвортой санхүүжилт	3-р сарын 29	100
4.	Нягтлан бодох бүртгэл болон аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, өөрчлөлт болон тоон гарын үсгийн хэрэглээ, хэрэгжүүлэлт	6-р сарын 3	140

“Business breakfast”

Бизнес эрхлэгчдийг төртэй холбох, төр хувийн хэвшлийн түншлэлийг сайржуулах зорилгоор энэ оны 2-р сараас эхлэн “Business breakfast” өглөөний уулзалтуудыг нийт 6 удаа зохион байгуулсан. Салбарын асуудал эрхэлсэн сайд нар болон УИХ дахь 2 намын бүлгэмийн дарга нартай уулзах тус тус уулзалтыг давхардсан тоогоор 350 орчим бизнес эрхлэгчдийн дунд амжилттай зохион байгуулж Бизнес эрхлэгчдэд асуудлаа хэлэх, дуу хоолойгоо төрд хүргэх боломжийг бий болгож өгсөн.



№	Урилгаар оролцогчийн нэр	Хэзээ	Оролцогсдын тоо
1.	УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга С.Бямбацогт	2-р сарын 18	Танхимын удирдах зөвлөлийн гишүүд, бизнес эрхлэгчдийн төлөөлөл 45
2.	УИХ дахь Ардын намын бүлгийн дарга Б.Гарамгайбаатар	3-р сарын 29	Танхимын удирдах зөвлөлийн гишүүд, бизнес эрхлэгчдийн төлөөлөл 78
3.	Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ	4-р сарын 19	Барилгын дэд бүтцийн зөвлөлийн гишүүд, бизнес эрхлэгчдийн төлөөлөл 58
4.	Хууль зүйн сайд Д.Дорлигжав	4-р сарын 29	Танхимын гишүүд, бизнес эрхлэгчдийн төлөөлөл 48
5.	Хүнс хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа	5-р сарын 18	Газар тариалангийн үйлдвэрлэл, тариалал эрхлэдэг бизнес эрхлэгчдийн төлөөлөл 57
6.	Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат	5-р сарын 27	Бизнес эрхлэгчдийн төлөөлөл 58

Бусад арга хэмжээ:

1. Торгоны зам 2016” шагнал гардуулах ёслолын арга хэмжээ-40
2. “Ногоон технологи ба инноваци” зөвлөгөөн-120
3. “Усны үнэ цэнэ” форум -80
4. “Тогтвортой аялал жуулчлал” семинар-25
5. “Бизнес лиг-2016” 20 компанийн 200 гаруй хүн оролцсон

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, хэрэгжилт:

2016 онд шинээр 5 байгууллагатай хамтран ажиллах санамж бичгийг шинээр байгуулан үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2 байгууллагатай санамж бичиг зурахаар төслийг хэлэлцэж байна.

№	Байгууллагын нэр
Шинээр байгуулсан хамтын ажиллагааны санамж бичиг	
1.	Онцгой байдлын ерөнхий газар
2.	Монголын хөрөнгийн бирж
3.	Улаанбаатар төмөр замын үйлчилгээний төв
4.	Буянт-Ухаа трейд ХХК
5.	Монголын хуульчдын холбоо
6.	Скай хайпермаркет ХХК
Хамтын ажиллагааны санамж бичгийн төслүүд /ажиллаж байгаа/	
7.	Гааль, татварын ерөнхий газар
8.	БОНХАЖЯ-тай байгуулсан санамж бичгийг сунгах

Гадаад улс орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр:

№	Байгууллагын нэр
9.	Бразил Улсын Сан Паоло хотын ХАҮТ
10.	Унгарын ХАҮТ
11.	Унгарын Үндэсний худалдааны төв
12.	Татарстаны ХАҮТ

БИЗНЕС УУЛЗАЛТУУД

Бизнесийг бизнестэй, төртэй холбох, үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор том, жижиг 100 гаруй бизнес уулзалтуудыг зохион байгуулах, төрийн болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон. Дурдвал:

№	Агуулга	Тайлбар
1.	Монгол Японы бизнесийн харилцааг идэвхжүүлэх нь уулзалт, хэлэлцүүлэг	
2.	“Хуурай баяжуулах туршилтын үйлдвэрийн төсөл” хэрэгжүүлэхэд хамтрах хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг сонгох уулзалт	
3.	Эрээн хотын Хилийн чөлөөт бүсийн танилцуулга уулзалт	400 аж ахуй нэгжүүд
4.	Танхимын нээлттэй өдөрлөг” Баянзүрх дүүргийн бизнес эрхлэгчдийн чуулган	
5.	Тээвэр хөнгөвчлөх арга хэрэгсүүд, үндэсний семинар	100
6.	Худалдаа, тээврийн салбарын хаматрсан уулзалт	42
7.	2015 оны Entrepreneur шилдэг аж ахуй нэгж байгууллагуудын Туг өргөх ёслолын ажиллагаа	
8.	Эрдэм шинжилгээний өгүүллэгийн уралдаан	60
9.	“Махны экспортын төрийн бодлого, түүний хэрэгжилт” хэлэлцүүлэг	74
10.	Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улсын хооронд хэлэлцээр байгуулж хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан хийх ГХЯам хоорондын ноот солилцсонтой холбогдуулан мэдээлэл хийх арга хэмжээ	6 салбарын 37 төлөөлөгч
11.	Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс ба Япон Улс хоорондын хэлэлцээр 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан хэлэлцээрийн талаар дэлгэрэнгүй ойлголтыг хувийн хэвшлийнхэнд хүргэх уулзалт	200 гаруй бизнес эрхлэгч
12.	Канадын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтаар хэрэгжүүлэх Юнитерра хөтөлбөртэй хамтран Монгол улсын ноос ноолуурын салбарын бизнес эрхлэгчидтэй уулзалт	40
13.	НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас зохион байгуулсан "Монголын махны экспортыг нэмэгдүүлэх боломж" сэдэвт сургалт, хэлэлцүүлэг	58 мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн 68 төлөөлөгч
14.	"Монгол Хоккайдогогийн бизнесийн харилцааг идэвхижүүлэх нь" уулзалт	10
15.	Монгол-Унгарын бизнес форум	180
16.	Солонгос-Монголын бизнес форум	12
17.	Монгол-Тайваний бизнес форум	100
18.	Монгол-Австрийн бизнес форум	50
19.	“FT EBRD Төв Азийн хөрөнгө оруулалтын чуулган	

ҮЗЭСГЭЛЭН

ДОТООД:

№	Үзэсгэлэнгийн нэрс	Хэзээ	Тайлбар
1.	“Байгальд ээлтэй технологи, инноваци үзэсгэлэн	5-р сарын 10-11	150 хүн хамрагдсан
2.	Силк роуд 2015 арга хэмжээ	2-р сар	10 компани
3.	Монголд үйлдвэрлэв. Цагаан сар 2016 үзэсгэлэн	1-р сар	400 компани
4.	Ворота в Азию 2016	4-р сарын 19-21	ОХУ-ын 27 компани, Монголын 16 компани
5.	E-mart “Export to Korea”	5-р сарын 17	50 компани
6.	Олон улсын аялал жуулчлалын “Ай Ти Эм-2016” үзэсгэлэн		Танхимын зүгээс зөвлөлийн 50 гаруй гишүүн компани, нийт 250 гаруй байгууллага аж ахуйн нэгж оролцсон
7.	MICS-2016 Олон улсын үзэсгэлэн	6-р сарын 9-13	Дотоодын 75 аж ахуй нэгж, Гадаадын 10 аж ахуй нэгж оролцсон.
8.	Хөөрхөн ээж	5-р сарын 13-15	40 гаруй аж ахуй нэгж
9.	Mongolian mining 2016	4-р сарын 6-8	Хамтран ажилласан
10.	Safety expo	3-р сарын 24-26	Хамтран ажилласан

ГАДААД:

№	Үзэсгэлэнгийн нэрс	Хэзээ	Оролцогсдын тоо
11.	БНСУ-ын Илсан хотын Кинтекс Олон Улсын үзэсгэлэн	4 сарын 26-29-нд	6 компанийн 10 хүн
12.	Canton Fair 2016 олон улсын үзэсгэлэн	4-р сарын 15-21	22 хүн
13.	Олон улсын “Базаар Берлин” үзэсгэлэнд ЖДҮ, экспортлогчдыг зохион байгуулж оролцох		10 компани
14.	Малайз улсын Куала Лампур хотноо болсон “13 дахь удаагийн халал бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэн	3 сарын 29-31	16 компанийн 30 төлөөлөгч
15.	Харбины хүйтэн бүсийн олон улсын үзэсгэлэн	1-р сарын 5	30 компани 45 хүн
16.	Ий Үү хотын шилдэг импортын барааны үзэсгэлэн	5-р сарын 16-19	5 компани

СУРГАЛТ

БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН:

№	Сургалтын нэр	Тайлбар
1.	Хөдөлмөрийн яамны Эрүүл мэндийн төвтэй хамтран ХАБЭА, ажлын байрны эрүүл ахуйн талаар худалдаа эрхлэгчдэд зориулсан сургалт	40 гаруй
2.	“Компьютерийн сүлжээний мэргэжилтэн бэлтгэх” сургалт	6
3.	Gunter Pauli Монгол Германы Эдийн засгийн клубийн гишүүн Төвд агентураас Уугуул нутагтаа зохион явуулж буй "Change the rules of the game" - Тоглоомын дүрмээ өөрчлөө - нээлттэй лекц	80
4.	“Хямралын үеийн менежмент”	28
5.	Бизнесийн сургуулийн оюутнуудад танилцуулах сургалт, уулзалт	39
6.	Европын холбооны болон БНХАУ-ын импортын шаардлагуудын талаарх сургалт	90
7.	Аж ахуйн нэгжүүдэд зориулан "Хөрөнгө оруулалтын үнэлгээ" сургалтыг "Монгол япон төв"-өөс багш урин, зохион байгуулсан.	34
8.	Хамтын ажиллагааны төслийн хүрээнд төсөлд хамрагдаж буй аймгуудын болон УБ хот дахь мэргэжлийн холбоодын ажилтанууд, зарим салбар Танхимын ажилтануудыг "Кластерийн багийг хэрхэн удирдах вэ? сургалтыг.	2016 оны 4 сарын 4-8-ны өдрүүдэд зохион байгуулсан
9.	Тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ	Эко Ази байгаль орчны дээд сургуулийн магистр оюутнууд-12
10.	Номин Юнайтед ХХК-д очиж Номин сүлжээний байгууллагуудын удирдах ажилтнуудад “Органик бүтээгдэхүүн/certified organic” эко шошгоны шалгуурууд, журмын талаар сургалт хийсэн.	Номин сүлжээний дэлгүүрүүдэд органик бүтээгдэхүүний тасаг байгуулах эхний тохиролцоонд хүрэв. 40 /2016.5.26/

ТАНХИМЫН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН:

№	Сургалтын нэр
1.	Голландын ахмад экспертүүдийн холбооны ахмад эксперт Fred de Boer-ийн “Inside Out ба Дотоод боломжоо ашиглах нь” сэдэвт сургалт
2.	Эмч Д.Ган-Очирын зохион байгуулсан “Ханн веритас” эмчилгээний төвийн эмч нарын хийсэн “Хелико бактер гэж юу вэ, түүний тархалт” сэдэвт сургалт
3.	Танхимын ажилтан нарт зориулсан БСШУЯ-ны мэргэжилтэн Л.Отгонсүрэнгийн “Авъяас” хувь хүний хөгжил сэдэвт сургалт
4.	Европын холбооны Стандартыг боловсронгуй болгох төслийн санхүүжилтээр зохион байгуулагдсан ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоо ба дотоод аудитын 5 өдрийн сургалт
5.	Танхим дээр хэрэгжүүлж эхэлж байгаа Green HR системийн ажилчдад зориулсан сургалт
6.	“Маркетингийн үйл ажиллагааны төлөвлөгөө” сургалт
7.	“Цагийн менежмент” сургалт
8.	Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Л.Удвал болон ГХЯ-ны дэргэдэх академийн багш нарын “Яриа хэлэлцээр хийх ур чадвар” сэдэвт сургалт
11.	

СУДАЛГАА

№	Хийгдсэн судалгаа	
1.	Дэлхийн банкны "Бизнес эрхлэхүй" судалгааны хүрээнд Монгол улсын хил дамнасан худалдааны үзүүлэлтүүдээр судалгаа гаргах	
2.	Зах зээлийн тойм судалгаа	
3.	Өргөн хэрэглээний гол нэрийн бараа бүтээгдэхүүний судалгаа	
4.	"Монголын экспорт, импортын гол нэрийн барааны 2016 оны чиг хандлага"-ын судалгаа	
5	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа	
	Business Times сонины чанар, хүртээмжийн судалгаа	400 бизнесийн төлөөлөл хамруулав
	Гишүүнчлэлийн мэдээллийн сангийн талаарх судалгаа	88 бизнесийн төлөөлөл хамруулав
	Нэг цэгийн үйлчилгээний төвийн талаарх судалгаа	145 бизнесийн төлөөлөл хамруулав
	Арбитрын үйлчилгээний талаарх судалгаа	200 бизнесийн төлөөлөл хамруулав
	Business Breakfast уулзалтын судалгаа	50 бизнесийн төлөөлөл хамруулав
	B2B уулзалтын судалгаа	52 бизнесийн төлөөлөл хамруулав
	Танхимын нээлттэй өдөрлөгийн судалгаа	18 бизнесийн төлөөлөл хамруулав
	Boosting Mongolia арга хэмжээний судалгаа	52 бизнесийн төлөөлөл хамруулав
	Ажилчдын дотоод судалгаа	Бүх ажиллагсад

ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

Монгол Хятадын худалдааны маргаан эвлэрүүлэн зуучлах төвийг байгуулахаар Хятадын олон улсын худалдааг дэмжих хороо, Хятадын олон улсын бизнес эрхлэгчдийн холбооны эвлэрүүлэн зуучлах төв, МҮХАҮТ-ын дэргэдэх Эвлэрүүлэн зуучлах төв хамтран хамтын ажиллагааны хэлэлцээр байгууллаа.

№	Үйлчилгээ	Тоо	Тайлбар
1.	Гарал үүслийн гэрчилгээ	8000 гаруй гэрчилгээ олгосон	98 сая төгрөгийн орлого олсон.
	Салбар танхимаар дамжуулан олгосон гарал үүслийн гэрчилгээ /Дархан-уул, Сүхбаатар аймаг дахь ХАҮТ/	210	
2.	Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт эрхийн хамгаалалт, барааны тэмдэгтийн үйлчилгээ	Барааны тэмдэг – 64, ашигтай загвар – 2, шинэ бүтээл – 7	Нийт 34866\$ ажил хийгдэж, 26850\$ орлого олсон.
3.	Арбитрын хэрэг	82 хэрэг дээр ажиллагааг явуулж байгаагаас	41 хэрэг маргааныг шийдвэрлэсэн
4.	Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв	12 хүсэлт хүлээн авснаас	3 эвлэрэлийн гэрээ байгуулсан
5.	Хууль, бизнесийн эрх зүйн зөвлөгөө	500 гаруй	Эдийн засаг бизнесийн хууль тогтоомж, гэрээ хэлэлцээр, арбитраж эвлэрүүлэн зуучлалын талаар
6.	Давагдашгүй хүчин зүйл болон Хүнд нөхцөл байдлын гэрчилгээ	47 хүсэлт хүлээн авснаас	31 гэрчилгээ олгосон
7.	Зураасан код	200 гаруй байгууллагын 650 орчим бүтээгдэхүүн	
8.	АТА Карней форм	4	17679 \$-ийн бараа бүтээгдэхүүнд баталгаа гаргаж, 210\$ орлого оруулсан.
9.	Экспертиз	Экспертизийн ажлаар 1-р улиралд 33680000.₮-н орлого оруулсан	
10.	Органик бүтээгдэхүүний сертификат	8 бүтээгдэхүүн	4 компанийн 8 бүтээгдэхүүнд 4,5 сая төгрөг
11.	Ногоон буудал эко шошго	2 буудалд	600,000

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Ардчилсан оролцоотойгоор сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь төсөл

МҮХАҮТ, Монгол ажил олгогч эздийн холбоо, Улаанбаатар хотын худалдааны танхим, авлигатай тэмцэх газар болон азийн сан хамтран Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд 2016-2018 онуудад хэрэгжүүлэхээр болсон. Төслийн хүрээнд аж ахуй нэгж байгууллагын засаглалыг сайжруулах, ил тод байдлыг бэхжүүлэх зорилгоор судалгаа хийн, сургалт, уулзалтыг зохион байгуулж тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахаар болсон.

ГХАҮТХ-той хамтарсан хонины ноос, чацарганы нэмүү өртгийн сүлжээг дэмжих төсөл /2015.09-2018.08/

1. Увс аймгийн Улаангом хот орчмын чацаргана тариалагчдын судалгаа болон Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 6-р багт хонины ноосны судалгаа хийгдсэн.
2. Төслийн баг ноосны болон чацарганы салбарын мэргэжилтнүүдийн мэдээллийн бааз бүрдүүлсэн.
3. Увс аймгийн ХАҮТ-ын дэргэд Чацарганы салбарын кластер баг, Архангай аймгийн ХАҮТ-ын дэргэд хонины ноосны салбарыг дэмжих кластер багийг байгуулсан.
4. Төсөлд хамрагдаж буй мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулсан.
5. ШУТИС-ийн Хүнс Судлалын Төвтэй төслийн хүрээнд хамтран ажиллахаар болсон.
6. Улаанбаатар хотод хонины ноосоор хийсэн эсгий бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийгдэж эхлэх гэж байгаа.

Инкубатор төвийн төсөл

Азийн сангаас санхүүжүүлж буй “*Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих*” төслийн хүрээнд 2016 онд МҮХАҮТ-аас 22 нэр төрлийн сургалтыг зохион байгуулах гэрээ байгуулж, сургалтын модулийг боловсруулав. 2016 оны 07 дугаар сарын 20-ноос эхлэн сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

ТАНХИМЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МҮХАҮТ-ын дэргэд нийт 33 зөвлөл үйл ажиллагаа явуулж байна. 2016 оны эхний хагас жилд шинээр “Гарааны бизнесийг дэмжих” зөвлөлийг байгуулан даргаар нь “Будханат” ХХК Менежментийн зөвлөх Ч.Мөнхбадрах, нарийн бичгийн даргаар ЖДҮ, ХОДГ-ын мэргэжилтэн М.Золзаяа нар ажиллахаар болсон.

Зөвлөлийн нарийн бичгийн дарга нарыг чадвахижуулах зорилгоор Төр хувийн хэвшлийн хэлэлцэл, Оролцооны арга хэрэгсэл, Модераторын сургалтуудыг тус тус зохион байгуулсан.

Зөвлөлийн хүрээнд хийсэн томоохон арга хэмжээнээс дурьдвал:

1. **Захуудын зөвлөл:** Техникийн захуудын хүсэлтээр УИХ-ын Өргөдлийн байнгын хороо хуралдаж техникийн захуудыг нүүлгэх биш, нийслэл хотын баруун, зүүн 2 талд байлгах талаар хэлэлцэлд хүрсэн.
2. **Усны бодлогын зөвлөл:** 3 сарын 22-нд Дэлхийн усны өдрийг тохиолдуулан JCI Монгол байгууллага, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвтэй хамтран "Усны хомсдол ба хүн амын ус хангамжийн асуудал" форумыг зохион байгуулсан.
3. **Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зөвлөл:** Идэхийн тулд амьдрах уу? Амьдрахын тулд идэх үү? хүнс судлаач эрдэмтдийн чуулга уулзалт, уриалга, хэлэлцүүлэгийг 2016 оны 5-р сарын 26-ны өдөр зохион байгуулж, 70 эрдэмтэн, доктор, профессорууд цугларсан ба 5 эрдэмтэн, докторуудыг МҮХАҮТ-ын хийморь одонгоор шагнаж, 4 илтгэл, 1 уриалга явагдаж, салбарын дунд хэлэлцүүлэг өрнөсөн.
4. **Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл:** Монголын эдийн засгийн форумын "Эмэгтэйчүүдийн манлайлал" салбар хуралдааныг Зөвлөлийн дарга Л.Болормаа даргалж Панелистаар Ханбогд ХХК-ийн захирал Ч. Ганцэцэг нар оролцож зөвлөлийн гишүүдийн хамт амжилттай зохион байгуулсан.
5. **Шинжлэх ухаан, инновацийн зөвлөл:** Улс орны нийгэм-эдийн засгийн хүрээнд мэдлэгийн эдийн засаг, инновацийн талаарх ойлголт, мэдлэгийг түгээх, инновацийн соёл, бүтээлч сэтгэлгээг төлөвшүүлэх, ШУТ, инновацийн түншлэлийг хөгжүүлэх зорилгоор уламжлал болон зохион байгуулагдах болсон "Монголын инновацийн 7 хоног-2016" арга хэмжээ хоёрдахь жилдээ 2016 оны 5-р сарын 9-15-ны өдөр амжилттай зохион байгууллаа.
6. **Барилга дэд бүтцийн зөвлөл:** БХБЯам, Барилга МН-тэй хамтран нийт барилгынханд Барилгны тухай хуулийн тухай хэлэлцүүлгийг "Барилгын эрх зүй ба зах зээл" сэдвийн дор хийсэн. 100 гаруй бизнес эрхлэгчид оролцсон.
7. **Бичил санхүүгийн байгууллагуудын хөгжлийн зөвлөл :** “Сайн санхүүгийн орчин”-ыг бүрдүүлэх хүртээмжтэй санхүүжилтийн санаачлагыг хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллага, Бичил санхүүгийн байгууллагуудын хөгжлийн зөвлөл, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран байгуулав.
8. **ОХУ-тай ажиллах ажил хэргийн зөвлөл:** Алтанбулаг-2016 арга хэмжээг АҮЯ-тай хамтран зохион байгуулсан бөгөөд зөвлөлөөс махны экспортын бодлогоор илтгэл тавигдсан.

САЛБАР ТАНХИМУУД



2016 оны эхний хагас жилд Баян-өлгий, Дундговь, Дорноговь аймаг дахь салбарын танхимын дарга нар шинээр томилогдон, 6 ажилтан шинээр ажилд орсон байна.

1. 2016 оны 2-р сарын 17-18-ны өдрүүдэд Салбар танхимуудын тайлангийн хурлыг зохион байгуулж 17 салбар танхимын 26 хүн ирж оролцсон. Хурлын дараагаар ажилтнуудыг чадавхижуулах сургалтуудыг амжилттай зохион байгуулсан.

2. Салбар танхимыг чадавхижуулах чиглэлээр

“Төлөвлөлтийн менежмент”, “Мэргэжлийн багийг хэрхэн удирдах вэ?”, “Хөрөнгийн зах зээл”, “Компанийн нийгмийн хариуцлагын сургагч багш бэлтгэх сургалт” зэрэг 6 удаагийн сургалт явуулснаас давхардсан тоор 72 хүн хамрагдсан.

3. Европын сэргээн босголт хөгжлийн банкны “Холбоодыг чадавхжуулах” төсөлд нийт 11 салбар танхимд хамрагдаж өөрсдийн байгууллагын менежментийг хөгжүүлэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ аван үйл ажиллагаагаа сайжруулж байна.

4. Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтыг Хөвсгөл, Сүхбаатар, Говьсүмбэр аймгуудад зохион байгууллаа. Сургалтанд нийт 60 орчим хүн хамрагдаж Компанийн засаглалын гэрчилгээгээ авсан.



5. 2016 оны 4-р сарын 10-16-ны өдрүүдэд орлогч дарга М.Сарандаваа Эрээн-Замын-үүд-Дорноговь-Говьсүмбэр-Дундговь салбар танхимуудад 7 хоногийн турш ажилласан. Уулзалтын хугацаанд Эрээн хотын удирдлагатай уулзалт, Тесо ХХК-ны эрээн хот дахь төлөөлөгчийн газартай танилцах, Замын-Үүд чөлөөт бүстэй танилцах, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймаг дахь салбар танхимын бүх гишүүдийн хурлыг хийх, шинэ дарга болон шинэ тэргүүлэгч гишүүдийг томилох, аймгуудын засаг даргатай уулзах, аймгийн зах зээлтэй танилцах, танхимын гишүүн байгууллагын төлөөлөлтэй ажлын байранд нь очиж уулзах, салбар танхимуудын үйл ажиллагааг дэмжин урамшуулах чиглэлээр ажилласан.

ТАНХИМЫН ДОТООДОД ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛ, АЖЛУУД

Чанарын удирдлагын ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх

Чанарын удирдлагын ISO9001 стандарт 2015 онд дахин шинэчлэн батлагдсантай холбогдуулан Монгол улс 2016 оны 5 сард уг стандартыг орчуулан, үндэсний стандартаар баталсан. Энэхүү шинэчлэгдэн гарсан стандартыг байгууллагадаа нэвтрүүлэх зорилгоор Европын холбооны “Стандартыг тогтолцоог боловсронгуй болгох нь ” төслийн хүрээнд танхимын 25 ажилтнуудыг Чанарын удирдлагын тогтолцоогоор чадавхижуулах, бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх чадварыг эзэмшүүлэх зорилгоор “BSI” олон улсын стандартын итгэмжлэгдсэн байгууллагын ахлах зөвлөхөөр 5 өдрийн сургалтыг 4-р сарын 11-15-ны өдрүүдэд явуулан гэрчилгээ олгосон.

Одоо танхимын 15 газрын үйл ажиллагаан дээр зөрүүний шинжилгээ хийж байна.

Мөн 2016 оны 5 сарын 16-25 өдрүүдэд “Inside Out” буюу “Дотоод нөөц боломжоо ашиглах нь” сэдвт Танхимын нийт ажилтанг ЧУТ-г нэвтрүүлэхэд байгууллагын сэтгэлзүйг бэлдэх тухай РУМ-ын эксперт Fred de Voeg-ын сургалтыг 70-80 хүний бүрэлдхүүнтэй амжилттай зохион байгууллаа.